



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 15 өдөр

Дугаар А/16

Өвт

Ажлын хэсэг байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.3, 32.1.5 дахь заалт, Улсын Онцгой комиссын даргын 2021 оны “Түр журам батлах тухай” 03 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2021 оны “Түр журам батлах тухай” А/08 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлж буй “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн хүрээнд сумын малчин өрхөд малын тэжээл хүлээн авах, тараах ажлын хэсгийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Н.Бат-Эрдэнэ-Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Ч.Батдулам-Нягтлан бодогч

Э.Буянтогтох-Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Г.Сугар-Хөдөө аж ахуйн мэргэжилтэн

Э.Бадамханд-Хөдөө аж ахуйн мэргэжилтэн

Т.Жамъянжав-1 дүгээр багийн Засаг дарга

Д.Даваацэрэн-2 дугаар багийн Засаг дарга

С.Төмөр-3 дугаар багийн Засаг дарга

Г.Пүрэвтогтох-4 дүгээр багийн Засаг дарга


Л.Балжинням-5 дугаар багийн Засаг дарга

П.Мягмарсүрэн-Засаг даргын Тамгын газрын нярав

2. Суманд тэжээл хүлээн авах бэлэн байдлыг хангах, бүртгэх, ачиж буулгах, малчин өрхөд хүлээлгэж өгөх, тэжээлийг ирж авах боломжгүй малчин өрхийн тэжээлийг хүргэж өгөх ажлыг зохион байгуулахыг сумын Онцгой комисс (Н.Бат-Эрдэнэ)-д даалгасугай.

3. Малчдад тэжээлийг олгосон, хүлээн авсан тухай баримтыг гарын үсэг, малчны тамгаар баталгаажуулан баримтжуулж, үйл ажиллагааны тайлан, санхүүгийн холбогдох баримтыг заасан хугацаанд аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлж, ажиллахыг ажлын хэсэг (Н.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.АМГАЛАН